



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

“Эрдэнэбаян Арвижих” ХХК-ийн тусгай
зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.4, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эрдэнэбаян Арвижих” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсонтой холбогдуулан тус компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 9.3-т заасны дагуу архивын нэгж болгон цэгцэлж, 2012 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хорооны архивт хүлээлгэн өгөхийг “Эрдэнэбаян Арвижих” ХХК /Д.Эрдэнэчимэг/-д үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авах, холбогдох баримт хүлээлцэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН